

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ (2013 ОНЫ ЭХНИЙ 10 САРЫН БАЙДЛААР)

I. ТӨСӨВ:

Төсвийн орлого

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор эхний 10 сард аймгийн төсөвт 62553.9 сая төгрөгийн орлого орохоос 62637.4 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 100.1 хувьтай байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 4862.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 5368.4 сая төгрөгийн орлогыг оруулжээ.


Аймгийн төсвийн орлогын 91.4 хувийг тусламжийн орлогоор, 5.9 хувийг орлогын албан татвараар, 0.3 хувийг өмчийн татвараар, 1.1 хувийг бусад албан татвараар, 0.6 хувийг татварын бус орлогоор, 0.7 хувийг тусгай зориулалтын орлогоор бүрдүүлж байна.



Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр 49186.3 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Нийт зарлагын 45.6 хувийг цалин хөлс, 4.1 хувийг НДШ, 0.8 хувийг ЭМД, 29.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 19.5 хувийг татаас ба шилжүүлэг, 0.9 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.



Өглөг,авлага

Эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагууд 607.8 сая төгрөгийн өртэй байна.

Өглөгийн 8.7 хувийг түлш халаалтын зардал, 6.3 хувийг тээврийн зардал, 53.4 хувийг цалин, 4.0 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 4.3 хувийг хоолны зардал, 2.4 хувийг эмийн зардал, 20.9 хувийг бусад зардал тус тус эзэлж байна. Тухайн сард шинээр үүссэн өглөг 403.0 сая төгрөг буюу нийт өглөгийн 66.3 хувийг эзэлж байна.

II. АРИЛЖААНЫ БАНК.


Манай аймагт 2013 онд арилжааны 5 банкны салбар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Арилжааны банкны салбаруудаас аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл эхний 10 сард 115392.0 сая төгрөг болж, 58.3 хувь нь ХААН банк, 24.5 хувь нь Төрийн банк, 0.6 хувь нь Капитал банк, 16.6 хувь нь Хас банк-д ногдож байна. Зээлийн өрийн үлдэгдлийн 66.9 хувийг 2013 оны эхний 10 сард олгосон зээл эзэлж байна. Нийт зээлийн 0.3 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байна. Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 52842.6 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.

Байгууллага, иргэдийн хугацаатай ба хугацаагүй хадгаламж 47854.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 10496.6 сая төгрөг буюу 28.1 хувиар өссөн байна.

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ:

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 31923.7 сая төгрөг, зарлага 26820.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 6920.9 сая төгрөг буюу 27.7 хувиар, зарлага 3026.5 сая төгрөг буюу 12.7 хувиар тус тус өссөн байна. Нийгмийн даатгалын сайн дурын орлого 1103.9 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 402.7 сая төгрөг буюу 57.4 хувиар, эрүүл мэндийн сангийн орлого 697.8 сая төгрөг буюу 37.0 хувиар өсчээ. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 23841.0 сая төгрөг болсны 80.4 хувийг өндөр настны, 13.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 6.5 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад тэжээгчээ алдсаны тэтгэвэр 0.1 пунктээр буурч, өндөр настны тэтгэвэр 0.1 пунктээр өссөн байна.



Аймгийн хэмжээнд 12331 хүнд тэтгэвэр олгосны дотор өндөр насны тэтгэврийг 9337 хүнд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 1861 хүнд, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 912 хүнд тус тус олгожээ.

Эхний 10 сард 2067 хүнд 894.1 сая. төгрөгийн тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс тэтгэмж авагчдын тоо 257 хүнээр буюу 14.2 хувиар өсч, олгосон тэтгэмжийн хэмжээ 249.8 сая төгрөгөөр буюу 38.8 хувиар өссөн байна.

Эмнэлэгийн санхүүжилтэд 1903.8 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 197.2 сая төгрөг буюу 9.4 хувиар буурч, ажилгүйдлийн тэтгэмж 123.3 сая төгрөг буюу 3.1 дахин өсчээ.


Нийгмийн халамж:

Эхний 10 сард нийгмийн халамжийн сангаас /давхардсан тоогоор/ 31351 хүнд 8027.9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 3399 хүнээр буюу 12.2 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 2393.4 сая.төгрөг буюу 42.5 хувиар өссөн байна.Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж авагчдын 9.0 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 3.1 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 4.3 хувь нь ахмад настанг асарч буй иргэд, 0.2 хувь нь алдар цолтой ахмадууд, 31.2 хувь нь алдарт эхийн одонтой эхчүүд, 14.7 хувь нь жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхчүүд байна.Нийгмийн халамжийн сангаас 8027.9 сая.төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгосны 2587.3 сая.төгрөг буюу 32.2 хувийг халамжийн тэтгэвэрт, 1182.4 сая төгрөг буюу 14.7 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 69.2 сая төгрөг буюу 0.8 хувийг алдар цолтой ахмадуудад, 524.7 сая төгрөг буюу 6.5 хувийг ахмад настанг асарч буй иргэдэд, 387.8 сая төгрөг буюу 4.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд тус тус олгожээ.

IV.ХӨДӨӨ АЖ АХУЙ:


Аймгийн хэмжээгээр 2012 оны эцэст төллөх насны нийт 1190.5 мянган эх мал тоологдсон. 2013 оны эхний 10 сарын байдлаар 1113.0 мянган мал буюу оны эхэнд тоологдсон нийт эх малын 93.5 хувь нь төллөсөн байна. Урд оны мөн үед 901.5 мянган мал буюу оны эхний нийт эх малын мөн 93.0 хувь нь төллөөд байсан байна. Ингэний 43.9 хувь, гүүний 80.2 хувь, үнээний 85.4 хувь, эм хонины 94.4 хувь, эм ямааны 95.0 хувь нь төллөжээ.

Мал төллөлтийн хувь, 2013 оны эхний 10 сарын байдлаар




Гарсан төлийн 99.1 хувь буюу 1111.4 мянган төл бойжиж байна. Өмнөх оны мөн үед гарсан төлийн 99.3 хувь буюу 900.4 мянган төл бойжиж байсан байна.

Төл бойжилтын хувь, 2013 оны эхний 10 сарын байдлаар




Аймгийн хэмжээгээр 2013 оны эхний 10 сарын байдлаар 19 тэмээ, 748 адуу, 772 үхэр, 7740 хонь, 9196 ямаа буюу оны эхэнд тоологдсон нийт малын 0.62 хувьтай тэнцэх 18475 том мал зүй бусаар хорогдоод байна.

Зүй бусаар хорогдсон том мал, 2012 оны эхний 10 сарын байдлаар



Нийт хорогдсон малын 0.1 хувийг тэмээ, 4.0 хувийг адуу, 4.2 хувийг үхэр, 41.9 хувийг хонь, 49.8 хувийг ямаа эзэлж байна.


Зүй бусаар хорогдсон том малын бүтэц, төрлөөр



2013 оны эхний 10 сарын байдлаар Баян-Өндөр суманд 276 толгой мал буюу оны эхний нийт малын 0.1 хувь, Бүрд суманд 731 толгой мал буюу оны эхэнд тоологдсон нийт малын 0.3 хувь, Бат-Өлзий суманд 1390 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.0 хувь, Баруунбаян-улаан суманд 1054 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.7 хувь, Баянгол суманд 226 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.13 хувь, Гучин-Ус суманд 319 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.3 хувь, Есөнзүйл суманд

388 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.3 хувь, Өлзийт суманд 183 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.14 хувь, Зүүнбаян-Улаан суманд 2481 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 2.5 хувь, Богд суманд 141 толгой мал буюу оны эхэнд тоологдсон нийт малын 0.06 хувь, Нарийн тээл суманд 266 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.2 хувь, Сант суманд 144 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.12 хувь, Тарагт суманд 580 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.53 хувь, Төгрөг суманд 12 толгой мал, Уянга суманд 1648 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.9 хувь, Хайрхандулаан суманд 401 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.22 хувь, Хужирт суманд 1288 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.9 хувь, Хархорин суманд 6916 толгой мал буюу оны эхэнд тоологдсон нийт малын 3.6 хувь, Арвайхээр суманд 31 толгой мал тус тус зүй бусаар хорогдсон байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо, сумаар




Аймгийн хэмжээнд 2013 оны эхний 10 сард өвчнөөр 978 толгой мал хорогдсон ба энэ нь Бат-Өлзий суманд 321 толгой мал, Баруунбаян-Улаан суманд 9 толгой мал, Гучин-ус суманд 37 толгой мал, Есөнзүйл суманд 65 толгой мал, Төгрөг суманд 2 толгой мал, Уянга суманд 281 толгой мал, Хайрхандулаан суманд 19 толгой мал, Хужирт суманд 225 толгой мал, Хархорин суманд 17 толгой мал, Арвайхээр суманд 2 толгой мал тус тус хорогдоод байна. Урд оны мөн үед өвчнөөр 167 толгой мал хорогдсон байжээ.

Зүй бусаар хорогдсон том мал дотор хээлтэгчийн хорогдол эхний 10 сарын байдлаар 3120 толгой байгаа ба оны эхний нийт хээлтэгчийн 0.2 хувь нь хорогдоод байна. Нийт хорогдсон том малын 16.9 хувь нь хээлтэгч мал байна.


Аймгийн түүхий эдийн захад ямааны ноолуур 72000 төгрөг, тэмээний шир 15000 төгрөг, адууны шир 30000 төгрөг, үхрийн шир 1.8-2.3 метр урттай нь 30000 төгрөг, 2.3 метрээс дээш урттай нь 35000 төгрөг, хонины нэхий 8000 төгрөг /өлөн гэдэс ороогүй үнэ/, ямааны ноолууртай арьс 15000 төгрөгийн үнэ ханштай байна. Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд хонины нэхийний үнэ 33.3 хувиар, ямааны ноолуурын үнэ 71.4 хувиар, үхрийн ширний үнэ урд оноос том нь 16.6 хувь, жижиг нь 36.3 хувиар тус тус өссөн, ямааны арьсны үнэ өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 42.8 хувиар өссөн байна.

Ямааны ноолуурын дундаж үнэ, төгрөг




Аймгийн хэмжээнд 1631.2 га-д үр тариа, 330.3 га-д төмс, 163.6 га-д хүнсний ногоо тариалсан нь өмнөх онтой харьцуулахад үр тариа 1134.8 га-гаар бага, төмс 3.0 га-гаар илүү, хүнсний ногоо 4.1 га-гаар мөн илүү тариалсан. Ургац хураалтын хувьд үр тариа хураалт 1131.2 га-с 1303.0 тн, төмс 330.1 га-с 3747.5 тн, хүнсний ногоо 163.6 га-с 2076.3 тн ургац хураагаад байна. Малын тэжээл 774.3 га-д тариалсан ба хураалт 4163.8 тн байна. 10 сарын 30-ны байдлаар 31794.8 тн хадлан, 4912.2 тн гар тэжээл бэлтгээд байна.

Төмс, хүнсний ногоо хураан авалт



Малын тэжээл бэлтгэлт



V. АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд оны үнээр эхний 10 сард 12402.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 11774.8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс бүтээгдэхүүний үйлдвэрлэл 62.7 хувиар, борлуулалтын орлого 64.5 хувиар өссөн байна.

Энэхүү өсөлтөд нүүрс олборлолт, цэвэр ус, талх, нарийн боов, гурил, хэрчсэн гурил, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, гутал, оёдол, модон эдлэл, барилгын материал зэрэг үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 11.7 хувиас 2,9 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Харин архи, зайрмаг үйлдвэрлэл 20,0-35.7 хувиар буурсан байна.


Үйлдвэрлэл явуулсан цэг салбарыг мэдээнд нэмж хамруулсан нь аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний өсөлтөд зохих хэмжээгээр нөлөөллөө.

Үйлдвэрлэлт, борлуулалт, тэрбум төгрөг 2012-2013 он



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүнээс нүүрсний борлуулалт 1278.2 сая төгрөг, хүнсний бүтээгдэхүүн борлуулалт 5379.2 сая төгрөг, оёдолынх 285.6 сая. төгрөг, гутлынх 283.8 сая.төгрөг, мод, модон эдлэл, тавилгын борлуулалт 965.9 сая.төгрөг, бусад бүтээгдэхүүний борлуулалт 1886.3 сая төгрөг, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийнх 1695.7 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс нийт борлуулалтад нүүрс олборлолт 1.4 пунктээр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн борлуулалт 5.5 пунктээр, модон эдлэл, тавилгынх 6.1 пунктээр буурч, хүнсний бүтээгдэхүүн борлуулалт 6.1 пунктээр, оёдолынх 0.7 пунктээр, гутлынх 1.4 пунктээр, бусад бүтээгдэхүүн борлуулалтынх 5.1 пунктээр өсчээ.

Борлуулсан бүтээгдэхүүн салбарын бүтцээр




VI. ХОЛБОО, ТЭЭВЭР, ХУДАЛДАА:

Тээвэр

Авто замын тээврээр 2013 оны эхний 10 сард давхардсан тоогоор 171.7 мянган зорчигч зорчиж, 22.3 мян. тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс зорчигчдын тоо 13.9 мян. хүн буюу 8.8 хувь, тээсэн ачаа 2.6 мян.тн буюу 13.2 хувиар өсчээ.

Зорчигч эргэлт, тээсэн ачаа



Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр авто замын тээврийн салбарын орлого 2013 оны эхний 10 сард 1350.6 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 144.3 сая төгрөг буюу 12.0 хувиар өсчээ.

Холбоо

Холбооны тарифын орлого өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 14.6 хувиар өсч 408.2 сая төгрөг болсоны дотор хүн амаас орсон орлого 18.1 хувиар өсч 138.7 сая төгрөгт хүрсэн байна. Телефон цэгийн тоо 1012 байгаа нь урьд оны мөн үеийнхээс 4-өөр буурсан байна

VII. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ:

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлгийн 213 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж түүний үндсэн дээр инфляцыг тооцдог.


2013 оны 10 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарыхаас 2.6 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 15.5 хувиар, 2010 оны 12-р сарынхаас 35.3 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 09 дүгээр сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 213 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 24.9 хувийх нь үнэ өсч, 5.6 хувийх нь буурч, 69.5 хувийх нь үнэ тогтвортой байлаа.

Энэ сард өмнөх сарынхаас хонины ястай махны үнэ 5.2 хувиар, үхрийн ястай махны үнэ 7.1 хувиар, үхрийн цул махны үнэ 10.3 хувиар, ямааны ястай махны үнэ 12.7 хувиар, дотор мах цувдайны үнэ 25.0 хувиар, луувангийн үнэ 16.7 хувиар, сонгиноны үнэ 23.1 хувиар, эмний үнэ 2.9-17.8 хувиар буурч, адууны ястай махны үнэ 3.8 хувиар, жигнэмэгний үнэ 5.9 хувиар, боорцогны үнэ 2.1 хувиар, дээд гурилны үнэ 5.0 хувиар, 1-р гурилны үнэ 6.7 хувиар, 2-р гурилны үнэ 4.6 хувиар, элэгний нухашны үнэ 6.3 хувиар, цэвэр сүүний үнэ 6.3 хувиар, өндөгний үнэ 16.7 хувиар, ургамалын тосны үнэ 19.0 хувиар, мандарины үнэ 5.6 хувиар, хатуу чихэрний үнэ 5.3 хувиар, зөөлөн чихэрний үнэ 9.8 хувиар, кетчупны үнэ 3.0 хувиар, ногоон цайны үнэ 2.2 хувиар, ундааны үнэ 7.1 хувиар, дээлийн даавууны үнэ 6.7 хувиар, эрэгтэй хүрэмний үнэ 10.0 хувиар, эрэгтэй хүний ноосон цамцны үнэ 7.1 хувиар, эмэгтэй хүрэмний үнэ 23.1 хувиар, доторгүй хүрэмний үнэ 7.1 хувиар, хүүхдийн ноосон цамцны үнэ 9.1 хувиар, гуталны үнэ 5.3-20.0 хувиар, цементийн үнэ 20.0 хувиар, нүүрсний үнэ /1 шуудай/ 25.0 хувиар, цахилгаан барааны үнэ 1.8-13.6 хувиар, эдийн савангийн үнэ 6.7 хувиар, угаалгын нунтагны үнэ 5.0 хувиар, аяга таваг угаагч шингэний үнэ 9.4 хувиар, 00-н цаасны үнэ 29.6 хувиар тус тус өссөн байна.

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 57.3 хувийх нь буюу 122 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 5.6 хувийх нь үнэ буурч, 37.1 хувийх нь үнэ тогтвортой байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс сүү, аарц, гурил, будаа, хүнсний ногоо, ааруул,

тамхи, архи, дотуур, гадуур хувцас, гутал, гэр ахуйн хэрэгсэл, жимс, жимсгэнэ, бүх төрлийн мах, бензин, цэвэр усны үнэ, зэргийн үнэ 2.8 хувиас-92.3 хувиар нэмэгдсэн байна.



VIII. НИЙТ БАРАА ГҮЙЛГЭЭ:

Аймгийн хэмжээнд 2013 оны эхний 10 сард 38276.6 сая төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4298.4 сая төгрөг буюу 12.6 хувиар өссөн байна.

Бараа гүйлгээний орлого өмнөх оны мөн үеийнхээс 12.6 хувиар өсөхөд барааны дэлгүүрийнх 36.5 хувиар, хүнсний дэлгүүрийнх 18.8 хувиар, авто сэлбэгийнх 4.4 хувиар, барилгын материалынх 17.9 хувиар, авто засварын газрынх 6.6 хувиар, шатахуун борлуулалтынх 16.4 эм борлуулалтынх 4.5 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Бараа гүйлгээний орлогын 5.2 хувийг барааны дэлгүүр 25.0 хувийг хүнсний дэлгүүр, 2.8 хувийг авто сэлбэгийн дэлгүүр, 1.5 хувийг барилгын материалын дэлгүүр, 1.9 хувийг ресторан бар, 2.0 хувийг цайны газар, 0.2 хувийг түц 4.2 хувийг контейнер, 2.0 хувийг авто засварын газар, 52.1 хувийг шатахуун борлуулалт, 3.1 хувийг эм борлуулалтын орлого эзэлж байна.

IX. АЖИЛГҮЙЧҮҮД:

Аймгийн ХХҮХ-т бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 1532 болж, өмнөх оны мөн үеийнхээс 356 хүнээр буюу 18.9 хувиар буурчээ. 10 сард ажилгүй 944 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 460 иргэн ажилд зуучлагдан орсон байна. Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 855 буюу 55.8 хувь нь 15-34 насны залуучууд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 20.3 хувь нь дээд, 4.4 хувь нь тусгай дунд, 4.7 хувь нь мэргэжлийн анхан шатны, 38.6 хувь нь бүрэн дунд, 22.5 хувь нь бүрэн бус дунд, 8.4 хувь нь бага, 1.1 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дээд боловсролтой иргэдийн тоо 0.2 пунктээр, боловсролгүй иргэдийн тоо 0.6 пунктээр, мэргэжлийн анхан шатны боловсролтой иргэдийн тоо 1.5 пунктээр, тусгай дунд боловсролтой иргэдийн тоо 1.0 пунктээр, бага боловсролтой иргэдийн тоо 1.1 пунктээр буурч, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн тоо 0.9 пунктээр, бүрэн дунд 4.3 пунктээр тус тус өссөн байна. Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо 10 сард 460 болжээ. Ажилд зуучлагдан орсон нийт иргэдийн 20.2 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 63.0 хувь нь нөхөрлөл компанид, 14.3 хувь нь хоршоонд оржээ.

Шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүд болон ажилд зуучлагдан орсон хүний тоо



Х.АЖЛЫН ШИНЭ БАЙР:


Аймгийн хэмжээнд 10 сарын байдлаар 1979 ажлын байр шинээр бий болжээ.

Ажлын байрны 21.2 хувь нь ХАА-н салбарт, 23.3 хувь нь боловсруулах үйлдвэрт, 19.2 хувь нь барилгын салбарт, 8.0 хувь нь худалдааны салбарт, 28.3 хувь нь бусад салбарт бий болжээ. Ажлын байрны 28.8 хувь нь аймгийн төвд 71.2 хувь нь сумдад бий болжээ. Шинээр бий болсон ажлын байрны 28.8 хувь нь Арвайхээр суманд, 12.6 хувь нь Уянга суманд, 4.4 хувь нь Сант суманд, 3.3 хувь нь Баянгол суманд, 8.7 хувь нь Батөлзий суманд, 2.8 хувь нь Нарийнтээл суманд, 7.1 хувь нь Хархорин суманд, 27.9 хувь нь бусад сумдад бий болжээ. Ажилд орсон нийт хүмүүсийн 44.3 хувь буюу 877 нь эмэгтэйчүүд байна.

ХI.ЭРҮҮЛ МЭНД:

Аймгийн хэмжээнд эхний 10 сард 2324 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 146 эхээр буюу 6.7 хувь, төрсөн хүүхдийн тоо(амьд төрөлтөөр) 2324 болж, 138 хүүхэд буюу 6.3 хувиар өссөн байна.

Нэг хүртэлх насандаа 33 хүүхэд эндэж өмнөх оны мөн үеийнхээс 14 хүүхдээр буюу 29.8 хувиар буурсан байна.




Халдварт өвчнөөр эхний 10 сард 1142 хүн өвчилж өмнөх оны мөн үеийнхээс 372 хүнээр буюу 48.4 хувиар өссөний дотор гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 491 хүнээр буюу 3.3 дахин, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 61 хүнээр буюу 2.7 дахин, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 37 хүнээр буюу 49.3 хувиар, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 9 хүнээр буюу 14.7 хувиар, заг хүйтнээр өвчлөгчдийн тоо 2 хүнээр буюу 14.3 хувиар өсчээ.

Вируст гепатитаар өвчлөгчдийн тоо 146 хүнээр буюу 2.3 дахин, трихоминазаар өвчлөгчдийн тоо 42 хүнээр буурчээ.

Халдварт өвчин өмнөх оны мөн үеийнхээс Баян-Өндөр суманд 12 хүнээр, Хархорин суманд 34 хүн буюу 2.3 дахин, Арвайхээр суманд 373 хүн буюу 91.9 хувиар, Хужирт

суманд 33 хүн буюу 2.6 дахин, Гучинус суманд 12 хүнээр буюу 2.5 дахин, Хайрхандулаан суманд 20 хүнээр буюу 2.0 дахин, Төгрөг суманд 5 хүнээр буюу 83.3 хувиар, Сант суманд 1 хүнээр буюу 5.6 хувиар, Бүрд суманд 9 хүнээр буюу 3.2 дахин өсч, Бат-Өлзий суманд 13 хүнээр буюу 2.6 дахин, Богд суманд 37 хүнээр буюу 3.8 дахин, Тарагт суманд 15 хүнээр буюу 2.0 дахин буурчээ.

Арвайхээр суманд гахайн хавдраар 563 хүн, Хархорин суманд 26 хүн, Тарагт суманд 3 хүн, Төгрөг суманд 2 хүн, Баянгол суманд 12 хүн, Гучин ус суманд 15 хүн, ЗБУлаан суманд 8 хүн, Хайрхандулаан суманд 16 хүн, Хужирт суманд 14 хүн, Нарийнтээл суманд 25 хүн, Сант суманд 1 хүн, Бүрд суманд 8 хүн, Есөнзүйл суманд 3 хүн, Баянгол суманд 12 хүн, Богд суманд 2 хүн, Өлзийт суманд 1 хүн, Уянга суманд 1 хүн, тус тус өвчилжээ.



ХИ.ГЭМТ ХЭРЭГ:

Аймгийн хэмжээнд 10 сард 432 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 41 гэмт хэргээр буюу 8.7 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 63.9 хувь нь сумдад, 36.1 хувь нь аймгийн төвд бүртгэгджээ.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 12 хүүхдээр буюу 41.4 хувиар буурсан байна.Хулгайлах гэмт хэргийн 50.9 хувийг хувийн өмчийн хулгай, 37.7 хувийг малын хулгай, 11.4 хувийг мототциклийн хулгай тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс Хужирт суманд 23.8 хувиар, Богд суманд 2.6 дахин, Гучин ус суманд 2.3 дахин, Есөнзүйл суманд 28.6 хувиар, Өлзийт суманд 4.5 дахин, Уянга суманд 33.3 хувиар, Хайрхандулаан суманд 50.0 хувиар өсч, Баян-Өндөр суманд 22.2 хувиар, Сант суманд 2.6 дахин, Тарагт суманд 2.3 дахин, Хархорин суманд 45.5 хувиар, Нарийнтээл суманд 2.2 дахин, Арвайхээр суманд 4.3 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон 473 сэжигтэн, яллагдагчийн 255 хүн буюу 53.9 хувь нь 18-35 хүртэл насных, 196 хүн буюу 41.4 хувь нь 35-аас дээш насных, 22 хүн буюу 4.6 хувь нь 17 хүртэлх насныхан байна.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын 1.9 хувь нь оюутан, 13.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 27.9 хувь нь малчин, 40.2 хувь нь ажилгүй иргэд байна.

Түр саатуулсан тээврийн хэрэгсэл 3674 болж өмнөх оны мөн үеийнхээс 218 тээврийн хэрэгслээр буюу 5.6 хувиар, авто машин жолоодох эрхээ хасуулсан жолооч 76 хүнээр буюу 20.2 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 15.9 хувь нь гудамж талбайд үйлдэгдсэн байна.Нийт хэргийн 32.4 хувь нь согтуугаар, 26.1 хувь нь бүлэглэн үйлдсэн хэргүүд эзэлж байна.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 76.9 хувиар өсч, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 11.4 хувиар, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 13.8 хувиар буурчээ.

Гэмт хэргийн улмаас 582.2 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеийнхээс 17.2 сая төгрөг буюу 2.9 хувиар буурчээ. Нийт хохирлын 64.1 хувь буюу 373.4 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэргийн улмаас 83 хүн нас баржээ. Үүний 25.3 хувь нь хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас, 56.6 хувь нь золгүй учирлаар, 12.0 хувь нь бусдын гарт амь үрэгдсэн байна. Эмэгтэйчүүд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 9.4 хувиар өсчээ.

Аймгийн хэмжээнд 10 сард 1329 хүн эрүүлжүүлэгдэж, 439 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 81 буюу 6.5 хувиар, баривчлагдсан хүний тоо 87 буюу 24.7 хувиар өссөн байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
MAIN INDICATORS

13.06.11

Үзүүлэлтүүд	/Indicators/	Хэмжих нэгж /Unit/	2011	2012	2013	2013/ 2012 %
Төсвийн орлого	/budget revenue/	сая.төг mln.tog	4377.2	4220.2	5368.4	127.2
Төсвийн зарлага	/Budget expenditure/	сая.төг mln.tog	30802. 6	44526. 3	49186. 3	110.5
Зээлийн өрийн үлдэгдэл	/Remainder of loan debts/	сая.төг mln.tog	60457. 3	79303. 2	115392	145.5
Үүнээс: хугацаа хэтэрсэн	/whom: outstanding debts/	сая.төг mln.tog	698.7	162.3	318.9	196.5
Хадгаламж	/Deposits/	сая.төг mln.tog	30583. 1	37357. 5	47854. 1	128.1
Төллөсөн хээлтэгч	/Breeding stock/	мян.тол /thous.heads/	818.8	901.6	1113	123.4
Бойжсон төл	/rearing of young animals/	мян.тол /thous.heads/	794.2	900.5	1111.4	123.4
Том малын зүй бус хорогдол	/Losses of adult animals/	мян.тол /thous.heads/	20.8	6.9	18.4	266.7
Ургац хураалт /total crops / :						
Үр тариа /Cereals/		га/ hectare	2057.0	2983	1303	43.7
Төмс/Potatoes/		га/ hectare	3068.9	3662.6	3747.5	102.3
Хүнсний ногоо/Vegetable/		га/ hectare	1648.2	1991.7	2076.3	104.2
Байгалийн хадлан /gross hay harvest/		тн /tn/	31731. 5	31195. 9	31794. 8	101.9
Гар тэжээл / hand made fodder/		тн /tn/	5855.0	4991.1	4912.2	98.4
Аж үйлдвэрийн НБ	/Gross industrial outрут/	сая.төг mln.mog	5166.8	7625	12402. 1	162.7
Борлуулсан бүтээгдэхүүн	/Sold production/	сая.төг mln.tog	4887.2	7158.6	11774. 7	164.5
Тээсэн ачаа	/Carried freight/	мян.тн /thous.tn	16.5	19.7	22.3	113.2
Зорчигч зргэлт	/Passenger turnover/	мян.хүн.км /thouspass.k m/	42861	46393. 2	49920. 1	107.6
Холбооны орлого	/Revenue of communication/	сая.төг mln.tog	217.1	254.8	408.1	160.2
Телефон цэг	/Number of telephones/	тоо/number/	1035	1016	1012	99.6
Ажилгүйчүүд /Unemployment/		хүн/people/	2905	1888	1532	81.1
Халдварт өвчнөөр өвчлөгчид disease cases/	/number of infectious	хүн/people/	1103	770	1142	148.3
1 хүртэл насандаа эндсэн хүүхэд years/	/infant deaths at age of 1	хүн/people/	57	47	33	70.2
Бүртгэгдсэн хэрэг/Offences/		тоо/number/	393	473	432	91.3
Хэрэгт холбогдогсод /Offenders/		хүн/people/	369	457	473	103.5

1.ТӨСӨВ

BUDJET

I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО,оны үнээр,мян.төг
STATE BUDGET REVENUE OF AIMAG, at current prices, thous.tog

Төсвийн орлого	2012		2013		Budget revenue
	гүйц	төл	гүйц	төл	
Татварын орлого	3985679.4	4719338.7	4975104.3		Tax revenue
Орлогын албан татвар	2501975.8	3954323.8	3724615.9		-Individuals
- Өмчийн татвар	101146.8	95073.3	163850.8		-Property tax
- Бусад татвар	1013670	299781.6	666274		-Other tax
Татварын бус орлого	172041	143545	393278		Non-tax revenue
Хөрөнгийн орлого	62495.4	0	67		Capital revenue
Дүн	4220216	4862883.7	5368449.3		Total
Орлогын эх үүсвэр					
Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг		10834400.0	10740857.9		-Corporate tax
Тусгай зориулалтын шилжүүлгээс		29344462.0	29344462.0		
Аймаг нийслэлээс авсан санхүүгийн дэмжлэг		12663917.8	12536756.1		-Value added tax
Сум дүүргээс авсан тэгшитгэл		4848264.3	4646909.1		-Excise tax
Дүн	0.0	57691044	57268985		Total

I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА,оны үнээр,мян.төг
STATE BUDGET EXPENDITURE OF AIMAG, at current prices, thous.tog

Төсвийн зарлага	2012		2013		Budget expenditure
	гүйц	төл	гүйц	төл	
-Цалин хөлс	26463064	23021345	22453235		Wages&salaries
-Нийгмийн даатгалын шимтгэл	2222836	2116234.7	2037140		-Social security contribution
-Эрүүл мэндийн даатгал	449838.8	406082.8	403630		-Health insurance
-Бараа үйлчилгээний бусад зардал	9941774	17974030	14304600.6		-Goods and services expenses
Татаас ба шилжүүлэг	3723469	9857024.9	9586987.7		-Subsidie & transfers
-Хөрөнгө оруулалт	1725339	386993.4	400769.4		-Investment
НИЙТ ЗАРДАЛ	44526322	53761710.5	49186362.4		TOTAL EXPENDITURE

06-Nov-13

СЭЗТЦХ-ийн мэдээг үндэслэв.

1.2 ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА сумаар, оны үнээр, мян.төг
 BUDGET REVENUE, EXPENDITURE ,by soum , at current prices , thous.tog

Сум	Орлого Revenue			Зарлага Expenditure		
	2013			2013		
	төл	гүйц	%	төл	гүйц	%
Баян-Өндөр	74293.0	76552	103.0	1509636.2	1464373.5	97.0
Бүрд	73398.1	71128.7	96.9	1232829.2	1227592.6	99.6
Бат-Өлзий	197436	229936.8	116.5	2484556.9	2432760.3	97.9
ББ-Улаан	66014.6	79189.1	120.0	1527417.2	1195300.2	78.3
Баянгол	88325.6	77952	88.3	1391615.5	1430480.4	102.8
Гучин-Ус	68430.9	68463.3	100.0	1323221.4	1149966.3	86.9
Есөнзүйл	66649.2	69281.7	103.9	1353403.7	1337817.2	98.8
Өлзийт	52234.1	57910.2	110.9	1184555.2	1043052.5	88.1
ЗБ-Улаан	70555.2	91038.4	129.0	1167826.1	1258684.1	107.8
Богд	115487.9	103170.9	89.3	1756571.6	1800750.0	102.5
Нарийнтээл	110137	109869.6	99.8	1800250.2	1565450.5	87.0
Сант	79553.9	78613.1	98.8	1409478.6	1366953.9	97.0
Тарагт	71315	73401.3	102.9	1301877.2	1268028.0	97.4
Төгрөг	63426	68011.4	107.2	1371456.4	1305377.2	95.2
Уянга	274570.6	444648.3	161.9	3188667.9	3047774.7	95.6
Хайрхандулаан	66691.2	61265.5	91.9	1338806.7	1314838.8	98.2
Хужирт	246884.3	319716.7	129.5	2613101.1	2476786.6	94.8
Хархорин	653527.1	712090.9	109.0	4133254.3	3960825.0	95.8
Арвайхээр	2610076	2446835	93.7	8963716.5	8649369.9	96.5
Сум дүн Soum total	5049005.7	5239075.0	103.8	41052241.9	39296182	95.7
Аимгийн шууд	-186122.0	129374.3	(69.5)	12709468.6	9890180.7	77.8
Аймаг дүн Aimag total	4862883.7	5368449.3	110.4	53761710.5	49186362.4	91.5

07-Nov-13

СЭЗТСХ-ийн мэдээг үндэслэв.

ӨГЛӨГИЙН МЭДЭЭ

13.05.11

	Нийт өглөг	Үүнээс:										
		Ажиллагсад олгох цалин	Нийгмийн даатгалын шимтгэл	мэндийн даатгалын	Гэрэл цахилгаан	Тулш халаалт	Тээвэр	Шуудан холбоо	Хоол	Эм	Бусад	
Эхний үлдэгдэл	327019.3	41049.8	25572.5	0	6918.8	28399.6	50798	8.5	18946	21102.9	134223.1	
Тухайн сард төлөгдсөн өглөг	122225.8	12290.9	2173.8	0	550.1	10872.5	29738.1	0	9047	12691.1	44862.3	
Тухайн сард шинээр үүсэн өглөг	403016.8	296037	1040.9	0	393.6	35531.4	17188.4	435	16318	6468.8	29604.6	
Эцсийн үлдэгдэл	607810.3	324796	24439.6	0	6762.3	53058.5	38248.3	443.5	26217	14880.6	118965.4	
өглөг үүсэн хугацаа	31-60 өдөр	273921.0	29371.3	22275.4	0	955.4	49074.4	28489.6	443.5	22192	10471.2	110647.8
	61-120 өдөр	329843.7	295424	918.6	0	5806.9	3984.1	9258.7	0	1724	4409.4	8317.6
	121 өдрөөс дээш	4045.6	0	1245.6	0	0	0	500	0	2300	0	

БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА /мян.төг/

13.05.10

д/д	Үзүүлэлтүүд	Indicators	ХААН банк	Төрийн банк	ХАС банк	Капитал банк	Голомт банк
1	Монгол банкнаас арилжааны банкуудад хийсэн зузаатгал		11466036.0	2529836.0	1799186.0	194000.0	4094872.0
2	Банкны кассын орлого		56823250.0	28162457.2	40899043.8	5057434.6	12128489.7
3	Монгол банкинд гүйлгээнээс орсон татаас		26691660.0	182300.0	3212200.0	995370.0	3298710.0
4	Банкны кассын зарлага		42548979.0	28379217.6	40941234.2	4323790.4	12943651.1
5	Зээлийн өрийн бүх үлдэгдэл		67232549.0	28242921.9	19221232.9	695402.2	0.0
6	Үүнээс: Хугацаа хэтэрсэн зээл		135846.0	26806.0	156262.5	0.0	0.0
7	Байгууллага, иргэдийн хувийн хадгаламж		26906552.0	11295601.6	7462178.2	534358.0	1655382.6
8	Дүн		231804872.0	98819140.3	113691337.6	11800355.2	34121105.4

Нийгмийн даатгалын сангуудын зарцуулалтын мэдээ

мян.төг

Үзүүлэлтүүд						Өссөн дүнгээр		
1	Нийгмийн даатгалын сангуудын нийт орлого					Төлөвлөгөө	29531364.0	
						Гүйцэтгэл	31923665.8	
						Хувь	108.1	
	Орлого	Үүнээс	Төсвийн дотац			Төлөвлөгөө	19261813.3	
						Гүйцэтгэл	19261813.3	
						Хувь	100.0	
			НДШ-ийн орлого			Төлөвлөгөө	10269550.7	
						Гүйцэтгэл	12661852.5	
						Хувь	123.3	
		Үүнээс	Нийгмийн даатгалын сайн дурын орлого			Төлөвлөгөө	476961.4	
						Гүйцэтгэл	1103919.3	
						Хувь	231.4	
		Үүнээс	Үүнээс	ЭМД-ын сангийн орлого			Төлөвлөгөө	2016230.0
							Гүйцэтгэл	2581037.0
							Хувь	128.0
Үүнээс	Үүнээс	ЭМД-ын хураамж	Төлөвлөгөө	101270.0				
			Гүйцэтгэл	226746.8				
			Хувь	223.9				
2	Зарлага	Тэтгэвэр			Хүний тоо	12331		
					Олгосон нь	23841039.0		
		Үүнээс	Өндөр настны			Хүний тоо	9337	
						Олгосон нь	19174001.4	
			ХБИргэдийн			Хүний тоо	1861	
						Олгосон нь	3114768.7	
		Тэжээгчээ алдсаны			Хүний тоо	912		
					Олгосон нь	1552268.8		
		Тэтгэмж			Хүний тоо	2067		
					Олгосон нь	894096.6		
		Эмнэлгийн санхүүжилт			Олговол зохих нь	1903855.5		
					Олгосон нь	1903855.5		
		Ажилгүйдлийн тэтгэмжид олгосон			Хүний тоо	215		
					Олгосон нь	181344.1		
3	НДШ-ийн авлага			Бүгд		24162.7		
